



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 268


Улаанбаатар хот

“Соёмбо даатгал” ХХК-д даатгалын хэлбэрийн зөвшөөрөл
нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3.23 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Соёмбо даатгал” ХХК-д барилга угсралтын даатгалын хэлбэрээр ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нэмж олгосугай.

2. Тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын биелэлтэд хяналт тавьж, “Соёмбо даатгал” ХХК-ийн ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад энэ тогтоолын 1 дэх хэсэгт заасан даатгалын хэлбэрээр нэмж бүртгэн олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН